




МОНОС
ХҮНС



2023



ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

ЦЭЦЭГ АБ

БҮТЭЦ

1	Компанийн тухай	2
	ТУЗ-ийн даргын мэндчилгээ	3
	Төлөөлөн удирдах зөвлөл	4
	Компанийн философи	5
	Түүхэн товчоо	6
	Хэрэгжүүлж буй стандартууд	8
2	Бүтээгдэхүүн & Экспорт	9
3	Санхүүгийн тайлан 2023	11
	Санхүүгийн тайлан мэдээлэл	12
	Голлох үзүүлэлтүүд	14
4	2023 оны үйл явдлын тойм	15
	Нийгэмд үзүүлсэн эерэг нөлөө	16
	Онцлох үйл явдлууд	18
5	Тогтвортой хөгжлийн зорилт	19
	Байгаль орчин, нийгэм, засаглал	21
6	MFC 2.0 төслийн танилцуулга	23



КОМПАНИЙН
ТУХАЙ

ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрлэлийн тэргүүлэгч Монос Хүнс ХК-ийн эрхэм хэрэглэгчид, 13 мянга гаруй хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Нийгэм эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн хомсдол зэрэг олон сорилтууд дунд үйл ажиллагааны чиг баримжаа, алсын хараа эрхэм зорилгоосоо хазайлгүй хэрэглэгчдийнхээ эрүүл мэндийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйлсэд хувь нэмрээ оруулж буй Монос Хүнс ХК нь 2023 онд бүтээн байгуулалтын өрнүүн амжилттай ажилласныг дуулгахад таатай байна.

Бид 2023 онд өмнөх онтой харьцуулахад борлуулалтын орлогоо 12%, цэвэр ашгаа 9%-аар өсгөхийн хажуугаар 22 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий Нэгдсэн үйлдвэрийн MFC 2.0 төслөө амжилттайгаар хэрэгжүүлж байна. Ингэснээр Монос Хүнс ХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадал 3 дахин нэмэгдэж эрүүл мэндийн хүнсээ хэрэглэгчдэдээ улам хүртээмжтэй болгох боломжтой боллоо. Өнгөрөгч 11 жилийн хугацаанд Монос Хүнс ХК нь 3 дахь үйлдвэрийн төслөө амжилттай хэрэгжүүлж байгаа нь энэ билээ.

Үйл ажиллагаа, хүчин чадал нэмэгдэхийн хэрээр экспортын борлуулалтыг нэмэгдүүлэх боломж гарч Төв Азийн орнуудад бүтээгдэхүүнээ бүртгэлжүүлж эхний байдлаар Киргиз улсын зах зээлд 3 брэндийн 20 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж эхлээд байна.

Түүнчлэн 2023 онд байгаль орчин, нийгэм, засаглалын /ESG/ үнэлгээг анх удаа хийлгэж Тогтвортой хөгжлийн зорилтод хамт олноороо хэрхэн хувь нэмрээ оруулж буйгаа тодорхойллоо.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс Гүйцэтгэх удирдлагын багийн гаргаж буй Тогтвортой Хөгжлийн Бодлогод хувь нэмрээ оруулах, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулахад чиглэсэн санаачилга, амлалтуудыг бүрэн дэмжиж ажиллаж байна.

Бид бүхний энэ хичээл зүтгэлийг үргэлж дэмжин эрүүл, чанартай бүтээгдэхүүнийг сонгон хэрэглэдэг эрхэм хэрэглэгчид, итгэл хүлээлгэн хамтран ажилладаг итгэлтэй харилцагч, хөрөнгө оруулагч нийт хувьцаа эзэмшигч та бүхэндээ чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд цаашид арвин их амжилтыг хамтдаа бүтээхийн ерөөл дэвшүүлье.



Монос Хүнс ХК-ийн
ТУЗ-ийн дарга

Х.Ананд

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Л.Хүрэлбаатар
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Группийн үүсгэн
байгуулагч, Монгол Улсын
Хөдөлмөрийн баатар, Академич



Х.Ананд
ТУЗ-ИЙН ДАРГА
Монос Групп
Гүйцэтгэх захирал



А.Отгондарь
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Хүнс ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Х.Солонго
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Групп Үйл
ажиллагаа эрхэлсэн захирал



Д.Энхтүвшин
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ТУЗ-ийн дэргэдэх Стратеги бизнес
хөгжлийн хорооны дарга
МҮХАҮТ-ын ерөнхийлөгч



Ц.Цэцэгбадам
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
Монос Групп Санхүү
эрхэлсэн захирал



О.Лхагвасүрэн
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга
Сэцэн Билгүүн ХХК Гүйцэтгэх захирал



Ч.Баттогтох
ТУЗ-ИЙН ГИШҮҮН
АШУИС-ийн
тэнхимийн эрхлэгч



Б.Гантулга
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон
цалин урамшууллын хорооны дарга
Сүү ХК-ийн Гүйцэтгэх захирал

БИЗНЕСИЙН ФИЛОСОФИ UPDATE & RESTART

2023 онд Monos Хүнс компани БОНЗ-ын үнэлгээ хийлгэж Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хийж буй үйл ажиллагаагаа ОУ-д мөрдөж буй стандартын дагуу олон нийтэд тайлагналаа. Компани 2023 оны 6-р сард "Тулгын 3-н чулуу" сэдэвт "Retreat" арга хэмжээг зохион байгуулан БОНЗ-ын бодлогоо хэлэлцэн тодорхойлсон. Ингэснээр БОНЗ-ын бодлого нь компанийн зорилго, зорилтын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон. Улмаар 2023 оны 4-р улиралд "Retreat" арга хэмжээгээ "Update and Restart" сэдвээр зохион байгуулж компанийн бизнес философио Байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого, үзэл баримтлалдаа нийцүүлэн Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлээ шинэчлэн тодорхойлсон.

ӨМНӨ

АЛСЫН ХАРАА:

ЭРҮҮЛ мэндийг дэмжсэн
ОРГАНИК хүнсний
бүтээгдэхүүнийг өдөр тутмын
хэрэглээнд хэвшүүлэх.



ОДОО

АЛСЫН ХАРАА:

Эх дэлхийгээ хайрлаж,
Эрүүл амьдралыг хамтдаа
бүтээнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эрүүл мэндийг дэмжсэн
хүнсний бүтээгдэхүүнийг,
хэрэглэгчийн сэтгэл
ханамжид нийцүүлэн, олон
улсын стандартаар
ҮЙЛДВЭРЛЭГЧ,
ЭКСПОРТЛОГЧ, дотоодын зах
зээлд ТЭРГҮҮЛЭГЧ компани
байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Хүрээлэн буй орчин,
оролцогч талуудаа хүндэлсэн,
эрүүл амьдралын хэв маягийг
дэлгэрүүлэгч, үнэ цэн бүтээгч
компани байна.

ҮНЭТ ЗҮЙЛС:

Эрхэм хэрэглэгч Эрүүл,
чанартай бүтээгдэхүүн
Итгэлтэй харилцагч Ёс зүйтэй
бизнес Мэдлэг, чадвартай
бүтээлч хамт олон Шинэ
санал, санаачилга



ҮНЭТ ЗҮЙЛ:



Оролцогч
талууд



Инновацлаг
бүтээгдэхүүн



Эерэг соёл

ТҮҮХЭН ТОВЧОО

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав. Эрүүл мэндийн ус, ундааны цехийг ашиглалтад оруулав.

2013

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

2014

ODOO ERP /Enterprise Resource Planning/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

2015

Монгол Улсад анх удаа эрүүл мэндийг дэмжсэн үйлдэлтэй Монголчуудын хооллолтын онцлог дээр тулгуурлан хүчил шүлтийн харьцааг тэнцвэржүүлэх Экос pH8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.

2016

Монгол Улсад анх удаа уусдаг цайны төрөлд импортийг орлох аньс, нэрс, чацаргана жимстэй өнгө үнэр амт орлуулагч ашиглаагүй Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.

2017

Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.

2018

Өтгөрүүлсэн Барагшун бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж эхлэв. Монос Хүнс компани биет бус хөрөнгөө үнэлүүлсэн Монголын анхны компани болов.

2019

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO хийж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав.



БАРАГШУН НЬ ТӨРӨЛ БҮРИЙН ГАРАЛТАЙ ХАРШИЛ, АРСНЫ ВВЧНИЙГ НАМЖААНА

МОНОС ХҮНС | IPO

ЭРҮҮЛ МЭНДЭЭ ДЭМЖИХ ИТЭЛТЭЙ ХӨРӨНГӨ БРИУЛАЛТ



ТҮҮХЭН ТОВЧОО

2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо болох ISO22000:2018 болон Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн “Shot” 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.



2022

“Монос Хүнс” ХК нь Австри улсад төвтэй “TSC” /The chilled Snack Company/ компанийн ОХУ дахь салбар “TSC Food Products Ru” компанитай хамтран ажиллаж Милино брэндийн Творожное Драже үрлийг тус улсын зах зээлд амжилттай гаргалаа. Тус бүтээгдэхүүнийг Киргиз болон Евразийн 5 улсад гаргах боломж бүрдлээ.



2023

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж “Хэнэгтэй Монгол Эр хүн” төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх нийгмийн нөлөөллийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүргэж чадлаа.



Мөн 2023 онд Бүгд Найрамдах Киргиз улсын эм ханган нийлүүлэх Лекарь компаниар дамжуулан 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ албан ёсны эрхтэйгээр тус улсад худалдан борлуулахаар боллоо.





ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ СТАНДАРТУУД



Чанарын
менежментийн
тогтолцоо
ISO 9001:2015



FSSC 22000
Хүнсний аюулгүй
байдлын тогтолцоо
FSSC 22000



Лабораторийн
ISO 17025



Байгаль орчны
чанарын удирдлагын
тогтолцоо
ISO 14001



2

БҮТЭЭГДЭХҮҮН
& ЭКСПОРТ

БҮТЭЭГДЭХҮҮН & ЭКСПОРТ

КИРГИЗ-ЛЕКАРЬ

Монос Хүнс ХК, Бүгд Найрамдах Киргиз улсад 20 нэр төрлийн бүтээгдэхүүнээ экспортлохоор боллоо.



LIFE CYKEL

Увдист брэндийн Өтгөрүүлсэн барагшун бүтээгдэхүүн АНУ болон Австралийн зах зээлд гарахад бэлэн боллоо.



МИЛИНО

“Монос Хүнс” ХК уламжлалт цагаан идээ болох ааруулыг тараг болон чацаргана жимсээр баяжуулсан “BerryVit” үрлээ ОХУ-д худалдаалах зорилгоор “Милино” брэндийг хөгжүүлэн “Творожное Драже” буюу “Ааруултай үрэл” нэрээр 2023 оноос экспортолж эхлээд байна.



NEVA BUYERS

“Монос Хүнс” ХК-ийн хөгжүүлсэн “Милино” брэндийн “Творожное Драже” тарагтай ааруултай үрэл ОХУ-д зохион байгуулагдсан “Neva Buyers Week” ОУ-ын үзэсгэлэнгийн “Эрүүл амьдралын хэв маягт нийцсэн бүтээгдэхүүн” төрөлд нэр дэвшин “Инновацлаг бүтээгдэхүүн”-ээр шалгарч АЛТАН медаль хүртлээ.



3

САНХҮҮГИЙН
ТАЙЛАН 2023

Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2022 он Аудитлагдсан	2023 он Аудитлагдсан	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
				2022 он	2023 он
ХӨРӨНГӨ	36,507.6	77,336.5	112%	100%	100%
Эргэлтийн хөрөнгө	12,472.5	39,163.2	214%	34%	51%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	295.5	27,537.5	9218%	1%	36%
Дансны авлага	3,586.9	3,956.9	10%	10%	5%
Татвар, НДШ - ийн авлага	45.6	2,174.9	4669%	0%	3%
Бусад авлага	181.4	155.9	-14%	0%	0%
Бараа материал	7,750.0	4,944.9	-36%	21%	6%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	613.1	393.1	-36%	2%	1%
Эргэлтийн бус хөрөнгө	24,035.0	38,173.3	59%	66%	49%
Үндсэн хөрөнгө	22,188.4	37,399.9	69%	61%	48%
Биет бус хөрөнгө	525.8	414.0	-21%	1%	1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	70.2	76.1	8%	0%	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,250.6	283.2	-77%	3%	0%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	36,507.6	77,336.5	112%	100%	100%
Өр төлбөр	19,216.9	55,330.3	188%	53%	72%
Богино хугацаат өр төлбөр	14,545.7	19,484.5	34%	40%	25%
Дансны өглөг	1,270.1	1,079.6	-15%	3%	1%
Цалингийн өглөг	178.7	164.5	-8%	0%	0%
Татварын өр	1,707.3	1,688.1	-1%	5%	2%
НДШ-ийн өглөг	228.2	151.5	-34%	1%	0%
Богино хугацаат зээл	10,584.9	15,184.9	43%	29%	20%
Зээлийн хүүгийн өглөг	105.9	249.5	136%	0%	0%
Ногдол ашгийн өглөг	0.0	0.0		0%	0%
Урьдчилж орсон орлого	58.7	48.5	-17%	0%	0%
Нөөц өр төлбөр	150.4	211.0	40%	0%	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	261.5	706.9	170%	1%	1%


Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2022 он	2023 он	Өөрчлөлт %	Нийт хөрөнгөд эзлэх %	
	Аудитлагдсан	Аудитлагдсан		2022 он	2023 он
Урт хугацаат өр төлбөр	4,671.2	35,845.8	667%	13%	46%
Урт хугацаат зээл	4,671.2	29,025.6	521%	13%	38%
Нөөц өр төлбөр	0.0	6,449.5		0%	8%
Хойшлогдсон татварын өр	0.0	213.5		0%	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	0.0	157.2		0%	0%
Эздийн өмч	17,290.7	22,006.2	27%	47%	28%
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%	6%	3%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%	19%	9%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	410.9	2,508.1	510%	1%	3%
Хуримтлагдсан ашиг	7,725.8	10,344.2	34%	21%	13%

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2022 он	2023 он	Өөрчлөлт %
	Аудитлагдсан	Аудитлагдсан	
Борлуулалтын орлого (цэвэр)	28,216.6	31,676.9	12%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,928.7	17,203.8	8%
Нийт ашиг (алдагдал)	12,287.9	14,473.1	18%
Бусад орлого	74.4	46.6	-37%
Борлуулалт, маркетингийн зардал	5,100.6	6,711.2	32%
Ерөнхий ба удирдлагын зардал	2,668.4	3,029.5	14%
Санхүүгийн зардал	648.7	635.7	-2%
Бусад зардал	163.6	207.9	27%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-152.1	-18.1	-88%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,628.9	3,917.4	8%
Орлогын албан татвар	441.6	437.1	-1%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,187.3	3,480.3	9%

ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /САЯ.ТӨГ/





2023 ОНЫ ҮЙЛ
ЯВДЛЫН ТОЙМ

#UnListenTheStereotype

Henegtei Mongol Man



THE STATUES OF THE MOST POWERFUL, DEIFIED, AND INFLUENTIAL PEOPLE OF ALL TIME

THE PROBLEM

Research conducted by the World Health Organization in 2020 shows that the global life expectancy was 73.2, of which 71.6 for female life expectancy is 75.6, while that of the male is 70.8. But in Mongolia, the male life expectancy is 10 years shorter than females. 6 out of 10 male Mongolians don't make it to the age of 60.

Male Mongolians are leading the world in the number of deaths in multiple categories:

- #1 #1 #1 #2 #6 9/10
- Accidental death
- Alcohol-related death
- Cardiovascular death
- Diabetes death
- Ischaemic heart disease death
- Stroke death
- World Health Organization

Over the past 5 years, multiple campaigns advocating health and self-care were launched in Mongolia. But they were ineffective and society seems to be embracing ignorance over these topics.

THE INSIGHT

A leading producer of health-promoting food and beverage supplements, Monol Foods JSC, has concluded that the main reason for the high death rate of male Mongolians is their "care-free" mindset. This "care-free" mindset is ingrained in Mongolian culture and is a result of harmful stereotypes inflicted upon men over many years.

THE IDEA

In order to break the traditional stereotypes such as men should be bold and men shouldn't cry, we have come up with the new concept, "Unlisten the Stereotype" to promote a genuine acceptance of healthy and positive masculinity.

We brought the concept to public attention in a new and disruptive way by putting headphones on the statues of the most powerful, deified, and influential people of all time. We also put headphones on the famous contemporary sculptures and placed them where the public often visit to share our message with a wider audience and advocated the idea of redefining the modern Mongolian man.

THE RESULT

This is the first time that the topic of stereotypes was boldly raised to the public, creating an opportunity to make a positive impact in the long run.

We called out to male Mongolians to love themselves more, care for themselves more, and live with a more conscious approach to life, and recommended concrete actions and actions to move towards that goal.

HENEGTEI-CARE'FUL'

New word added to the Mongolian vocabulary

REDEFINED

Modern Mongolian Man

VOLUNTARY PARTNERSHIP

Influencers, Hospitals & Insurance companies

22 MILLION Impressions


745 MILLION Earned Media




НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭРЭГ НӨЛӨӨ

“ХЭНЭГТЭЙ МОНГОЛ ЭР ХҮН” НИЙГМИЙН НӨЛӨӨЛЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК, Монгол эрэгтэйчүүдийн эрүүл мэндэд анхаарал хандуулж “Хэнэгтэй Монгол Эр хүн” төслийг амжилттай эхлүүлж эрэгтэйчүүдийн тухай хэвшмэл ойлголтыг халах, өөрчлөх нийгмийн нөлөөллийн төслийг амжилттай хэрэгжүүлж давхардсан тоогоор 22 сая хүнд хүрч бодитоор эрүүл мэнддээ анхаарал хандуулах ойлголтыг эрэгтэйчүүдэд төрүүлж чадлаа.



“ҮРСЭЭ УСТАЙ ҮЛДЭЭ” УРИАГ ОЛОН НИЙТЭД ХОНОГШУУЛЛАА




Монос Хүнс ХК-ийн Экос брэндийн зүгээс “Үрсээ устай үлдээ” хэмээх уриалгыг дэвшүүлж “Моод” контенттэй хамтран орон сууцны айлуудад усаа хэмнэх жишгийг харуулсан нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд хүргэж 30 хүртэлх хувиар усаа хэмнэх бодит шийдлийг харуулж чадлаа.

МОНОС ХҮНС ХК ДАХИН НЭГ ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙГ ТОХИЖУУЛЖ ӨГЛӨӨ

Монос Хүнс ХК, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ГССҮТ-ийн Түлэгдлийн эмнэлгийн, түлэнхийн нөхөн сэргээх хүүхдийн тасгийн тоглоомын өрөөг иж бүрэн засварлан, тохижуулж өглөө.



ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛ ХИЙЖ БАЙНА



Монос Хүнс ХК, 2023 оны эхний хагаст иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сувиллын өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулж 1500 орчим амрагч, сувилуулагч иргэнийг хамрууллаа. Мөн 120 орчим мянган дагагчтай Монос Хүнс фэйсбүүк хуудсаараа дамжуулан “MFC ADVICE” нэртэй эмчийн зөвлөгөө видеог тогтмол хүргэн ажиллаж байна. Мөн Employee branding “MFC FAMILY” видео контенттой болоод байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

МОНОС ХҮНС ХК 10 МЯНГА ГАРУЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧТЭЙ БОЛОО

Монос Хүнс хувьцаат компани анх 2019 онд IPO гаргаж байхдаа 4004 хувьцаа эзэмшигчтэй байсан бол 2023 онд 10 мянга гаруй хувьцаа эзэмшигчтэй боллоо.



САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ЭНТРЕПЕНЕР-2023 ШАГНАЛЫГ ХҮРТЛЭЭ

Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын нэрэмжит Оны онцлох "Сайн засаглалыг хэрэгжүүлэгч Энтрепеленер"-2023 шагналыг хүртлээ.



АРД ТҮМНИЙ ХҮНС 2024 - ЭКОС

Экос эрүүл амьдралын ус 2024 оны "Ард түмний хүнс"-ээр тодорлоо



5

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТ

		БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ	ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО	НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	ИЛ ТОД БАЙДАЛ
3	ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ	ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ				
4	ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ	ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ				
5	ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ	ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ				
6	БАТАЛГААТ ҮНДНЬ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ	БАТАЛГААТ ҮНДНЬ УС АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ				
7	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ НЭВТРҮҮЛЭХ				
8	ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ	ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ				
9	ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ	ИННОВАЦИ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ				
10	ТЭГШ БҮС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ	ТЭГШ БҮС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ				
12	ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ	ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ				
13	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨГ БАГАСТАХ	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨГ БАГАСТАХ				
16	ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЕСЫГ ЦОГЦЛООХ	ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЕСЫГ ЦОГЦЛООХ				

 ГОЛ ЧИГЛЭЛ

 АМЛАЛТ

ESG | БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

Байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг нийт 225 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 153 шалгуур БҮРЭН БИЕЛСЭН, 24 шалгуур бүрэн бус, 48 шалгуур биелээгүй байна. БОНЗ-ын үнэлгээний шалгууруудыг нэгдсэн оноогоор авч үзвэл нийт 10 оноо авах ёстойгоос 6.9 оноог авсан байна.



ESG | БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

● Нийгэмд эергээр нөлөөлөгч

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарт үндэсний болон олон улсын стандартыг мөрдөж ажиллах тал дээр салбартаа жишиг тогтоож байна.

Нийгмийн олон талт ялгаатай байдлын оролцоо, тэгш боломжийг хангагч

ХБИ, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад насныханд ажиллахад таатай ажлын байр бий болгож тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна нийгмийн идэвхтэй гишүүн байх боломжийг бүрдүүлж байна.

Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг эрхэмлэгч

Хог хаягдлын менежментийг сайжруулах, байгалийн нөөцийн зөв зохистой хэрэглээг дээшлүүлэх, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад хувь нэмрээ оруулж ажиллаж байна.

● Хариуцлагатай ажил олгогч

Ажилтнууд олон улсын сайн туршлагуудаас сурч хөгжих, хувь хүний үнэ цэнээ нэмэгдүүлэх, албан тушаал ахихад нь тэгш боломжоор ханган дэмжин ажилладаг.

“Монос Хүнс” ХК нь Байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээг “Ризилиенс консалтинг сервис” ХХК-аар хийлгэж нийт 225 шалгуур үзүүлэлтээс 153 шалгуурыг хангаж ESG-ын үнэлгээгээр нийгмийн хариуцлага ухамсарлан, үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм, засаглалын хувьд арвин ололт амжилттай, үйл ажиллагаа нь сайн дадалтай байгаа гэж дүгнэгдлээ.



**МФС 2.0 ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**

MFC 2.0 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монос Хүнс Хувьцаат компани 2019 онд IPO гаргаж дэлхийн стандартыг бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй үйлдвэрийг барьж байгуулан эрүүл мэндийг дэмжсэн шингэн болон хуурай хүнсний 8 брэндийн 87 бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байна.



“Монос Хүнс” ХК эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлж MFC 2.0 үйлдвэрийг ашиглалтад орууллаа. Ингэснээр ажилтнуудын амралтын өрөө, фитнес иогийн танхим, хоол, хурлын заал бүхий 6352 мкв үйлдвэр оффисын нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалтыг хийлээ. MFC 2.0 төсөл хэрэгжсэнээр компанийн бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангах, халуун савлагааг бүрэн ашиглалтад оруулах, Экос ус савлах шинэ шугам суурилуулах, биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааны бүтээмжийг 260% нэмэгдүүлэх, үйлдвэр, агуулахыг нэг дор төвлөрүүлэх боломж бүрдэж байна.

MFC 2.0 ТӨСЛӨӨ АМЖИЛТТАЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЖ ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ 95 ХУВЬТАЙ ЯВЖ БАЙНА

Монос Хүнс ХК 2022 онд эхлүүлсэн MFC 2.0 төслөө 2023 онд амжилттай үргэлжлүүлж 2023 оны жилийн эцэст барилга, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл 95 гаруй хувьтай үйлдвэр оффисын нэгдсэн барилгыг ашиглалтад оруулж дараагийн шатны ажлууд үргэлжилж байна.

ҮЙЛДВЭРИЙН АВТОМАТЖИЛТ


- Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэг зэрэг үйлдвэрлэх
- Үйлдвэр-оффисын хосолмол шийдлийг бий болгох, ажилчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Үйл ажиллагаа өргөжиж, борлуулалтын орлого нэмэгдэх
- Шинэ брэнд бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай үйлдвэрлэн гаргах юм.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бид 2024 ондоо ESG-ийн тогтолцоог хэрэгжүүлж байгаль орчиндоо ээлтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.



ESG САЙЖРУУЛАЛТ



Экос эеелэн ус савлахад ашиглагдаж буй **ХУВАНЦРЫН ХЭРЭГЛЭЭ** 35 хувиар бууруулна.




Цайны сав баглаа боодлын цаас болон **УУТНЫ ХЭРЭГЛЭЭГ** 90 хувь буурууллаа.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭГ 20 хувиар бууруулна.



Үйл ажиллагааг нэг дор төвлөрүүлэх цогц шийдэл нь түүхий эд материал болон бэлэн бүтээгдэхүүн **ТЭЭВЭРЛЭХ ЗАМЫН УРТЫГ** 11 дахин буурууллаа.



Үйлдвэрлэлийн явцад бий болох **СААРАЛ УСЫГ АХУЙН ХЭРЭГЛЭЭ** болон мод зүлэг услах, зам талбайн арчилгаанд бүрэн хэрэглэнэ.


ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Шинэ үйлдвэр ашиглалтад орсноор Экос усны үйлдвэрлэл 3 дахин нэмэгдэнэ.



29/25 СТАНДАРТ

Экос **УСНЫ САВ ИЛҮҮ НИМГЭН** болж шинэчлэгдэнэ. Ингэснээр Экос усны хуванцар савлагаа 6-16 граммаар буурч байгаль орчиндоо илүү ээлтэй болж байна.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН CRAFT, VITA500, ISOTONIC

MFC 2.0 төслийн хүрээнд импортыг орлох **CRAFT, VITA 500, ISOTONIC** бүтээгдэхүүнүүдийг зах зээлд шинээр гаргана.

ЭКСПОРТ

2024 онд MFC 2.0 төсөл хэрэгжиж үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдсэнээр экспортын гарц улам бүр нэмэгдэнэ.

MFC 2.0

ҮЙЛДВЭРИЙН НЭГДСЭН ЦОГЦОЛБОР

2024 онд Монос Хүнс ХК, бизнесийн ирээдүйгээ шинээр тодорхойлж, хөгжлийн дараагийн үе шатад гаргах, **ХУУРАЙ, ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР БОЛОН ОФФИС** нэгдэж байна.



ХҮНИЙ НӨӨЦ +25%

Монос Хүнс ХК нь 2023 онд ажлын байрыг тогтвортой хадгалж нийт 250 орчим ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ирэх онд **АЖЛЫН БАЙРНЫ ТООГ 25 ХУВИАР НЭМЭХ** төлөвлөгөөтэй байна.



МОНОС

ХҮНС

ТӨВ ОФФИС:
Монос Хүнс ХК-ийн Үйлдвэр, Сонсголонгийн
зам гудамж, 32/3 тоот, Үйлдвэрийн баруун бүс,
БГД, 20-р хороо, Улаанбаатар, 16103, Монгол улс

 www.monosfoods.mn

 foods@monos.mn

 MonosFoods

 976- 7777-3525